



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 07 өдөр

Дугаар А/55

Чойр

Хариуцлагатай жижүүр томилох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 77 дугаар зүйлийн 77.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сар шинийн баярыг тохиолдуулан 2024 оны 02 дугаар сарын 10-ны өдрөөс 2024 оны 02 дугаар сарын 12-ны өдрийг дуустал хугацаанд ажиллах аймгийн хариуцлагатай жижүүрийн хуваарийг 1 дүгээр, гүйцэтгэх үүргийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.


2.Аймгийн нутаг дэвсгэрт болзошгүй гэмт хэрэг, зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам хангах ажлыг зохион байгуулж ажиллахыг аймгийн Цагдаагийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа (Ц.Баярхүү), Гамшгаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга, хурандаа (Х.Сүхбаатар), яаралтай тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангаж ажиллахыг аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга (У.Ариун-Эрдэнэ), инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийн найдвартай тасралтгүй байдлыг ханган ажиллахыг ус, дулаан, цахилгаанаар хангагч байгууллагын дарга, удирдлагуудад, захирамжийн 2 дугаар хавсралтад заагдсан үүргийг хэрэгжүүлж ажиллахыг жижүүрийн үүрэг гүйцэтгэж байгаа удирдах албан тушаалтнуудад тус тус үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, мэдээллээр хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Содном)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.БАТСУУРЬ



Аймгийн Засаг даргын 2024
оны 02 дугаар сарын 07-ны
өдрийн 17 дугаар захирамжийн
... дүгээр хавсралт

ХАРИУЦЛАГАТАЙ ЖИЖҮҮРИЙН ХУВААРЬ

№	Байгууллага, албан тушаал	Овог. нэр	Утас	Огноо	Цагийн хуваарь
1	Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга	Т.Баясгалан	99998594	2024.02.10	08:30-12:30
2	Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн хэлтсийн даргын үүргийг тор орлон гүйцэтгэгч	У.Занабазар	99683840		12:30-16:30
3	Цахим үйлчилгээний хэлтсийн дарга	Э.Энх-Орчлон	99755665		16:30-20:30
4	Авто тээврийн төвийн дарга	Н.Мөнхнаран	99199390		20:30-24:00
5	ПТКоллежийн захирал	Ш.Отгонжаргал	91924441	2024.02.11	08:30-12:30
6	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга	Б.Отгончимэг	88093824		12:30-16:30
7	Улсын бүртгэлийн хэлтсийн дарга	З.Баяндугар	99297097		16:30-20.30
8	Стандарт хэмжил зүйн хэлтсийн дарга	Л.Жамбаасүрэн	99087761		20:30-24:00
9	Насан туршийн боловсролын төвийн захирал	Г.Баасансүрэн	98116544	2024.02.12	08:30-12:30
10	Боржигин өв музейн захирал	А.Ундармаа	99014021		12:30-16:30
11	Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар	Ц.Оюунбилэг	95800101		16:30-20.30
12	Худалдан авах ажиллагааны газрын дарга	Б.Болд-Эрдэнэ	95451198		20:30-24:00

Аймгийн Засаг даргын 2024 оны
02 дугаар сарын 06-ны өдрийн
А/35 дугаар захирамжийн
хоёрдугаар хавсралт

АЙМГИЙН ХАРИУЦЛАГАТАЙ ЖИЖҮҮРИЙН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭХ УДИРДАХ АЛБАН ТУШААЛТНУУДЫН ҮҮРЭГ

1.Томилогдсон хариуцлагатай жижүүрүүд 2024 оны 02 дугаар сарын 10-ны өдрөөс 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдрүүдэд 08:30 цагаас 24:00 цагийн хооронд хуваарилагдсан цагтаа үүрэг гүйцэтгэнэ.

2.Аймгийн хэмжээний мэдээг 4 цаг тутамд сумдын Засаг даргын Тамгын газар, Цагдаагийн хэлтэс, Онцгой байдлын газар, Нэгдсэн эмнэлэг, Ус-Ду ОНӨААТҮГ, БЗӨБЦХС-ТӨХК-ийн Говьсүмбэр салбараас тус тус авч, шаардлагатай үйл ажиллагаатай биечлэн танилцаж, үүрэг, чиглэл, зөвлөмж өгч, биелэлтийг тооцно.

3.Томилогдсон хариуцлагатай жижүүр нь үүрэг гүйцэтгэх цагаас 10 минутын өмнө ирж өмнөх жижүүрээс гарын үсэг зуран ажлаа хүлээн авна.

4.Жижүүрийн үүрэг гүйцэтгэх хугацаандаа холбогдох үйл ажиллагааны чиглэлээр илтгэх хуудас бичнэ.

5.Жижүүрийн үүргийг дараагийн жижүүрт гарын үсэг зурж биечлэн хүлээлгэн өгнө.

6.Жижүүрийн үүрэг гүйцэтгэх хугацаанд шаардлагатай тохиолдолд аймгийн Засаг даргын орлогч, Засаг даргын Тамгын газрын даргад шуурхай мэдэгдэнэ.

7.Хариуцлагатай жижүүр нь аймгийн Засаг даргын Тамгын газрын 70543434 дугаарын утсаар мэдээллийг авч, түргэн, шуурхай холбогдох арга хэмжээг авна.

8.Жижүүрийн ажлыг хариуцлагагүй гүйцэтгэсэн тохиолдолд холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага тооцно.

Шаардлагатай утасны дугаар:

№	Байгууллага	Утасны дугаар
1	Засаг даргын орлогч Б.Наранбаатар	99006183
2	Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Д.Содном	99549014
3	Аймгийн Засаг даргын Тамгын газар /жижүүр/	70543163
4	Онцгой байдлын газар /жижүүр/	7054101, 70541109
5	Цагдаагийн хэлтэс /жижүүр/	7054102
6	Эмнэлэг /түргэн тусламж/	7054103
7	Цахилгаан түгээх сүлжээ /жижүүр/	70543702
8	Ус Ду ОНӨААТҮГ /жижүүр/	70543125, 95953125

